БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ерөнхий боловсролын 1 сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/130/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Булган аймаг<br>2025 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас: 70342716 Цахим хаяг: @audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Аудитыг гүйцэтгэсэн: Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал С.Оргил<br>Утас:99197346<br>Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........................................3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........................................5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........................................7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................9
**3. АУДИТЫН ТАЙЛАН**........................................101-12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ........................................123-14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| МУЕА | Монгол Улсын ерөнхий аудитор |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| БГ | Боловсролын газар |
| СХДАГ | Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 278

танай ______ ны № ______ т

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН НЭГДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Э.ТҮВШИНМӨНХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Нэгдүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургууль нь 2025 онд 1533 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж, үүнээс 1521 хүүхэд үндсэн сургуульд, насан туршийн боловсролын хөтөлбөрт 12 хүүхэд хамрагдаж гүйцэтгэлээр 100 хувь санхүүжсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж 90.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

6326050299

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **445,437,005.36** | **402,983,082.22** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 221,144,469.18 | 73,305,791.64 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 221,144,469.18 | 73,305,791.64 |
| **3121** | **Төгрөг** | 221,144,469.18 | 73,305,791.64 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 221,144,469.18 | 73,305,791.64 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 224,292,536.18 | 329,677,290.58 |
| **351** | **Түүхий эд материал** | 56,612,408.80 | 101,199,493.20 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 56,320,408.80 | 100,907,493.20 |
| 35130 | Эм боох материал | 292,000.00 | 292,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 167,680,127.38 | 228,477,797.38 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,703,300.00 | 5,667,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 110,492,829.00 | 122,064,229.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 11,236,600.00 | 42,892,750.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,042,990.00 | 18,868,610.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 34,204,408.38 | 38,984,908.38 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,427,511,946.75** | **5,600,783,976.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,427,511,946.75 | 5,600,783,976.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,950,101,946.75 | 5,119,973,976.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,622,251,717.00 | 4,929,043,064.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (695,213,233.73) | (744,884,733.65) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,084,274,465.06 | 947,798,413.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (468,293,864.77) | (438,777,041.22) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 526,973,405.02 | 514,439,658.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (220,728,011.43) | (184,304,482.45) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 99,139,512.00 | 99,139,512.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (21,480,227.60) | (31,394,178.80) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,136,778.99 | 1,176,778.99 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,906,362.57) | (1,174,040.57) |
| 39217 | Ном | 22,947,768.78 | 28,911,026.38 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 477,410,000.00 | 480,810,000.00 |
| 39301 | Програм хангамж | 8,750,000.00 | 3,400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (8,750,000.00) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 477,410,000.00 | 477,410,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,872,948,952.11** | **6,003,767,058.97** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **76,593,145.00** | **78,540,266.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 76,593,145.00 | 78,540,266.00 |
| **413** | **Өглөг** | 76,593,145.00 | 78,540,266.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 70,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 76,593,145.00 | 78,470,266.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 76,593,145.00 | 73,652,266.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 4,818,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,796,355,807.11** | **5,925,226,792.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,796,355,807.11 | 5,925,226,792.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,256,550,162.42 | 1,256,550,162.42 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,256,550,162.42 | 1,256,550,162.42 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,157,926,695.59 | 3,229,990,254.49 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,157,926,695.59 | 3,157,926,695.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 72,063,558.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,381,878,949.10 | 1,438,686,376.06 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,872,948,952.11** | **6,003,767,058.97** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,825,930,242.40** | **5,953,522,339.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **196,452,242.40** | **448,944,240.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 196,452,242.40 | 448,944,240.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 196,452,242.40 | 448,944,240.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 196,452,242.40 | 448,944,240.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,629,478,000.00** | **5,504,578,099.99** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,154,013,000.00 | 4,726,494,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,154,013,000.00 | 4,726,494,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,000,000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,000,000.00 | 10,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 454,465,000.00 | 768,083,499.99 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 454,465,000.00 | 768,083,499.99 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,750,375,625.13** | **5,881,458,781.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,750,375,625.13** | **5,881,458,781.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,621,337,448.82 | 5,678,179,951.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,151,040,166.65 | 3,754,921,526.55 |
| 210101 | Үндсэн цалин | 2,085,489,957.65 | 2,305,796,083.02 |
| 210102 | Нэмэгдэл | 935,713,280.00 | 1,166,233,074.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 119,390,000.00 |
| 210104 | Урамшуулал | 129,836,929.00 | 163,502,368.69 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 390,418,342.95 | 456,398,555.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 265,981,407.72 | 314,119,001.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,972,808.18 | 36,368,614.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,828,115.06 | 18,334,649.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,127,196.74 | 18,086,029.18 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 60,508,815.25 | 69,490,261.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 441,956,933.69 | 677,480,810.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,986,777.69 | 54,181,417.90 |
| 210302 | Түлш, халаалт | 339,439,584.00 | 559,212,108.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 68,530,572.00 | 64,087,284.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 169,749,988.00 | 239,671,680.00 |
| 210502 | Хоол, хүнс | 169,749,988.00 | 239,671,680.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,455,600.00 | 63,155,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,455,600.00 | 63,155,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 54,921,087.15 | 45,570,820.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 54,921,087.15 | 45,570,820.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 402,795,330.38 | 440,981,158.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,528,384.00 | 93,559,985.97 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,311,980.00 | 18,991,420.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 297,954,966.38 | 328,429,752.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 129,038,176.31 | 203,278,829.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 129,030,110.00 | 192,676,140.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 129,030,110.00 | 192,676,140.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,066.31 | 10,602,689.89 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,066.31 | 10,602,689.89 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **75,554,617.27** | **72,063,558.90** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **75,554,617.27** | **72,063,558.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,657,399,300.00** | **5,511,247,699.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,921,300.00** | **6,669,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,921,300.00 | 6,669,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 14,180,000.00 | 540,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,180,000.00 | 540,000.00 |
| 120009 | Бусад орлого | 13,741,300.00 | 6,129,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,629,478,000.00** | **5,504,578,099.99** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,154,013,000.00 | 4,726,494,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,154,013,000.00 | 4,726,494,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,000,000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,000,000.00 | 10,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 454,465,000.00 | 768,083,499.99 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 454,465,000.00 | 768,083,499.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,515,754,465.80** | **5,604,858,677.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,515,754,465.80** | **5,604,858,677.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,399,944,889.49** | **5,390,375,477.64** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,151,037,322.70 | 3,754,731,652.81 |
| 210101 | Үндсэн цалин | 2,085,606,943.70 | 2,305,796,083.02 |
| 210102 | Нэмэгдэл | 935,593,450.00 | 1,166,233,074.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 116,940,073.00 |
| 210104 | Урамшуулал | 129,836,929.00 | 165,762,421.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 390,418,342.95 | 456,588,429.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 263,904,472.95 | 314,308,875.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,538,670.00 | 36,368,614.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,829,200.00 | 18,334,649.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,829,200.00 | 18,086,029.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 63,316,800.00 | 69,490,261.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 441,956,933.69 | 677,480,810.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,986,777.69 | 54,181,417.90 |
| 210302 | Түлш, халаалт | 339,439,584.00 | 559,212,108.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 68,530,572.00 | 64,087,284.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 174,410,674.00 | 240,222,930.00 |
| 210502 | Хоол, хүнс | 174,410,674.00 | 240,222,930.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,500,000.00 | 80,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,500,000.00 | 80,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 69,978,887.15 | 62,638,194.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,741,300.00 | 4,527,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 56,237,587.15 | 58,111,094.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 159,642,729.00 | 118,713,460.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 129,055,129.00 | 97,793,190.97 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 30,587,600.00 | 20,920,270.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **115,809,576.31** | **214,483,199.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 115,801,510.00 | 203,880,510.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 115,801,510.00 | 203,880,510.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,066.31 | 10,602,689.89 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,066.31 | 10,602,689.89 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **141,644,834.20** | **(93,610,977.54)** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **200,553,355.00** | **54,227,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **200,553,355.00** | **54,227,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 200,553,355.00 | 54,227,700.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 200,553,355.00 | 54,227,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(200,553,355.00)** | **(54,227,700.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (58,908,520.80) | (147,838,677.54) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 221,144,469.18 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 221,144,469.18 | 73,305,791.64 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,157,926,695.59** | 5,796,355,807.11 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,157,926,695.59** | 5,796,355,807.11 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,381,878,949.10** | **3,157,926,695.59** | 5,796,355,807.11 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | 56,807,426.96 | - | 56,807,426.96 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 72,063,558.90 | 72,063,558.90 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,256,550,162.42** | **1,438,686,376.06** | **3,229,990,254.49** | 5,925,226,792.97 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 5,510,707,699.99 | 5,510,707,699.99 | | 100 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,742,624,200.00 | 4,742,624,200.00 | | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,732,624,200.00 | 4,732,624,200.00 | | 100 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,000,000.00 | 10,000,000.00 | | 100 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 10,000,000.00 | | 100 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 768,083,499.99 | 768,083,499.99 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 768,083,499.99 | 768,083,499.99 | | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 6,669,600.00 | 6,669,600.00 | | 100 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 540,000.00 | 540,000.00 | | 100 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,517,377,299.99 | 5,517,377,299.99 | | 100 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,678,164,419.17 | 5,604,858,677.53 | 73,305,741.64 | 98.71 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,470,278,339.17 | 5,390,375,477.64 | 79,902,861.53 | 98.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,771,768,700.00 | 3,754,731,652.81 | 17,037,047.19 | 99.55 |
| 210101 | Үндсэн цалин | 2,476,247,800.00 | 2,305,796,083.02 | 170,451,716.98 | 93.12 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 1,188,375,000.00 | 1,166,233,074.84 | 22,141,925.16 | 98.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 116,940,073.00 | -116,940,073.00 | |
| 210104 | Урамшуулал | 107,145,900.00 | 165,762,421.95 | -58,616,521.95 | 154.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 458,371,100.00 | 456,588,429.26 | 1,782,670.74 | 99.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 315,100,400.00 | 314,308,875.35 | 791,524.65 | 99.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 36,517,600.00 | 36,368,614.37 | 148,985.63 | 99.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,358,800.00 | 18,334,649.27 | 24,150.73 | 99.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,358,800.00 | 18,086,029.18 | 272,770.82 | 98.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 70,035,500.00 | 69,490,261.09 | 545,238.91 | 99.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 688,083,499.99 | 677,480,810.10 | 10,602,689.89 | 98.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 50,000,000.00 | 54,181,417.90 | -4,181,417.90 | 108.36 |
| 210302 | Түлш, халаалт | 568,083,499.99 | 559,212,108.00 | 8,871,391.99 | 98.44 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 70,000,000.00 | 64,087,284.20 | 5,912,715.80 | 91.55 |
| 2105 | Нормативт зардал | 248,326,700.00 | 240,222,930.00 | 8,103,770.00 | 96.74 |
| 210502 | Хоол, хүнс | 248,326,700.00 | 240,222,930.00 | 8,103,770.00 | 96.74 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 80,000,000.00 | 80,000,000.00 | | 100 |
| 210604 | Урсгал засвар | 80,000,000.00 | 80,000,000.00 | | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 65,664,025.00 | 62,638,194.50 | 3,025,830.50 | 95.39 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,129,600.00 | 4,527,100.00 | 1,602,500.00 | 73.86 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 59,534,425.00 | 58,111,094.50 | 1,423,330.50 | 97.61 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 158,064,314.18 | 118,713,460.97 | 39,350,853.21 | 75.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 137,030,914.18 | 97,793,190.97 | 39,237,723.21 | 71.37 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,033,400.00 | 20,920,270.00 | 113,130.00 | 99.46 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 207,886,080.00 | 214,483,199.89 | -6,597,119.89 | 103.17 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 207,886,080.00 | 203,880,510.00 | 4,005,570.00 | 98.07 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 207,886,080.00 | 203,880,510.00 | 4,005,570.00 | 98.07 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 10,602,689.89 | -10,602,689.89 | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,602,689.89 | -10,602,689.89 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 54,227,700.00 | -54,227,700.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | | 54,227,700.00 | -54,227,700.00 | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 54,227,700.00 | -54,227,700.00 | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 5,678,164,419.17 | 5,659,086,377.53 | 19,078,041.64 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 221,144,469.18 | -221,144,469.18 | |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Булган сумын 1-р сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК”-ийн аудитын баг С.Дарьсүрэн, Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Булган сумын 1-р сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт зардлаас 4,716,307.8 мянган төгрөгийн 1.5 хувь 70,744.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувь 53,058.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас нийт 73,305.79 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож төрийн сангийн харилцах дансанд үлдээсэн байна. Орон нутгийн санхүүжилтээс 10,602.68 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

### 3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Булган сумын 1-р сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 171 мэдээллийг бүрэн оруулж мэдээлсэн байна.

### 3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд хийж гүйцэтгэсэн.

### 3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

- Тайлант жилд 1,207.8 мянган төгрөгийг зориулалт бус зардлын зөрчил илэрч төлбөрийн акт
- Тайлант жилд 3,413.0 төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага
- Тайлант онд багш нарт ур чадварын нэмэгдэл хавтайгуурлан олгосон тул зөвлөмжийг тус тус хүргүүлсэн
- *Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.*

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 1,207.8 | 2 | 1,207.8 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 3,413,0 | 1 | 3,413,0 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100.0 |
| Нийт дүн | 4 | 4,620.8 | 4 | 4,620.8 | 100.0 |

Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2025 оны 06 сарын 06-ны №194 тоот албан бичгээр хариу өгсөн байна.Шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлж ажилласан байна.

### 3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 1 зөрчил илэрч 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг бус алдаа тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 4.1 Зөвлөмж

Санхүүгийн прогроммыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй, бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Тасралтгүй байх зарчим”, 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээ үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж өгөх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн прогроммыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **1** | **0** | **-** | **-** | | | **1** | **0** | **-** | **-** | **-** | **-** |